

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/052/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАТСҮМБЭР СУМЫН БАЯНГОЛ ЦЭЦЭРЛЭГИЙН
2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор: Б.Адъяасүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: adiyasuren@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн:

Уваа уул аудит ХХК захирал:

Ч.Мөнхтуяа

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

Төв аймгийн Батсүмбэр сумын Баянгол цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2025.02.25 № 01/192
танай _____ -ны № _____ -т

ТӨВ АЙМГИЙН БАТСҮМБЭР
СУМЫН БАЯНГОЛ ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Д.БАТЧИМЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Батсүмбэр сумын Баянгол цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Батсүмбэр сумын Баянгол цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсролын ерөнхий газраас 6,703.4 мянган төгрөгийн тоглоом, 5,033.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж шилжүүлэн авсан байсан.

Аудитын гол асуудал

Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 184 ширхэг 35,343.6 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт бүхий нийт 41 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 86,3 хувиар дүгнэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

4126020223

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

Төв аймгийн Батсүмбэр сумын Баянгол цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	140,086,351.47	76,140,810.76
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	139,943,071.47	66,148,644.25
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	139,943,071.47	66,148,644.25
3121	Төгрөг	139,943,071.47	66,148,644.25
31211	Төрийн сангийн харилцах	139,943,071.47	66,148,644.25
33	АВЛАГА	-	600,000.01
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	600,000.01
35	БАРАА МАТЕРИАЛ	143,280.00	9,392,166.50
354	Хангамжийн материал	143,280.00	9,392,166.50
35420	Аж ахуйн материал	90,300.00	413,500.00
35450	Барилгын засварын материал	-	552,000.00
35460	Хүнсний материал	52,980.00	1,723,266.50
35470	Бусад хангамжийн материал	-	6,703,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	175,903,947.84	141,650,966.26
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	175,903,947.84	141,650,966.26
392	Биет хөрөнгө	175,903,947.84	141,650,966.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	179,279,220.05	179,279,220.05
39202	Хуримтлагдсан элэгдэл	(44,490,487.68)	(80,346,331.68)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	40,615,300.63	47,036,645.63
39206	Хуримтлагдсан элэгдэл	(24,561,322.34)	(27,941,390.01)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,067,174.23	26,090,174.23
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,037,897.56)	(15,865,345.15)
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,376,504.00	20,726,504.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,344,543.49)	(7,328,510.81)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	315,990,299.31	217,791,777.02
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	2,501,050.01
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	2,501,050.01
413	Өглөг	-	2,501,050.01
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	600,000.01
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	1,901,050.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	315,990,334.31	215,290,762.01
51	Засгийн газрын хувь оролцоо	315,990,334.31	215,290,762.01
512	Хуримтлагдсан үр дүн	315,990,334.31	215,290,762.01
51210	Өмнөх үеийн үр дүн	315,990,334.31	315,990,334.31
51220	Тайлант үеийн үр дүн	-	(100,699,572.30)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	315,990,334.31	217,791,812.02

Төв аймгийн Батсүмбэр сумын Баянгол цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	686,744,360.00	723,084,545.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,098,860.00	11,736,745.00
120	Нийтлэг татварын бус орлого	27,157,420.00	11,736,745.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	27,157,420.00	6,703,400.00
122	Тусламжийн орлого	7,941,440.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	7,941,440.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	651,645,500.00	711,347,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	627,358,400.00	678,980,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	627,358,400.00	678,980,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	24,287,100.00	32,366,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	24,287,100.00	32,366,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	598,621,380.76	823,784,117.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	598,621,380.76	823,784,117.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	595,795,659.24	816,933,704.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	417,819,659.11	599,366,438.44
210101	Үндсэн цалин	286,286,054.62	367,603,624.83
210102	Нэмэгдэл	124,051,964.49	198,703,438.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	13,325,000.00
210104	Урамшуулал	7,481,640.00	19,734,375.12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,824,399.98	67,903,083.78
210201	Тэтгэврийн даатгал	35,305,749.53	46,285,249.70
210202	Тэтгэмжийн даатгал	4,104,133.56	5,434,453.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,057,196.82	2,877,022.71
210204	Ажилгүйдлийн даатгал	2,050,084.89	2,620,390.89
210205	Эрүүл мэндийн даатгал	8,307,235.18	10,685,967.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,711,378.48	22,516,487.63
210301	Гэрэл, цахилгаан	2,096,164.38	7,329,850.05
210302	Түлш, халаалт	14,615,214.10	14,786,637.58
210303	Цэвэр, бохир ус	-	400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	855,900.00
210402	Тээвэр, шатахуун	-	855,900.00
2105	Нормативт зардал	51,217,823.25	61,349,618.50
210502	Хоол, хүнс	51,217,823.25	61,349,618.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	3,000,000.00
210604	Урсгал засвар	-	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,510,000.00	2,009,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,510,000.00	2,009,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,712,398.42	59,933,176.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,134,103.93	11,956,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,060,200.00	2,929,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	42,518,094.49	45,047,326.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,825,721.52	6,850,412.37
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,825,721.52	6,850,412.37
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,825,721.52	6,850,412.37
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	88,122,979.24	(100,699,572.30)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	35.00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	35.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(35.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	88,122,944.24	(100,699,572.30)

Төв аймгийн Батсүмбэр сумын Баянгол цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	651,645,500.00	711,347,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	651,645,500.00	711,347,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	627,358,400.00	678,980,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	627,358,400.00	678,980,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	24,287,100.00	32,366,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	24,287,100.00	32,366,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	565,829,876.26	779,381,227.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	565,829,876.26	779,381,227.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	563,004,154.74	772,530,814.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	417,819,659.10	599,366,438.44
210101	Үндсэн цалин	276,657,051.57	367,603,624.83
210102	Нэмэгдэл	133,680,967.53	198,703,438.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	13,325,000.00
210104	Урамшуулал	7,481,640.00	19,734,375.12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,824,399.98	67,903,083.78
210201	Тэтгэврийн даатгал	35,361,382.18	46,285,249.70
210202	Тэтгэмжийн даатгал	4,450,223.68	5,434,453.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,352,199.27	2,877,022.71
210204	Ажилгүйдлийн даатгал	2,248,689.00	2,620,390.89
210205	Эрүүл мэндийн даатгал	8,411,905.85	10,685,967.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,711,378.48	22,516,487.63
210301	Гэрэл, цахилгаан	2,096,164.38	7,329,850.05
210302	Түлш, халаалт	18,615,214.10	14,786,637.58
210303	Цэвэр, бохир ус	-	400,000.00
2105	Нормативт зардал	50,117,163.25	61,116,355.00
210502	Хоол, хүнс	50,117,163.25	61,116,355.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	750,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	750,000.00	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,510,000.00	2,009,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,510,000.00	2,009,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,271,553.93	16,619,450.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,861,353.93	12,158,650.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,410,200.00	4,460,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,825,721.52	6,850,412.37
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,825,721.52	6,850,412.37
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,825,721.52	6,850,412.37
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	85,815,623.74	(68,033,427.22)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	5,761,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	5,761,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	5,761,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	5,761,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(5,761,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	85,815,623.74	(73,794,427.22)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	54,127,447.73	139,943,071.47
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	139,943,071.47	66,148,644.25

Төв аймгийн Батсүмбэр сумын Баянгол цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	236,500,530.06	236,500,530.06
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	79,489,804.25	79,489,804.25
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	315,990,334.31	315,990,334.31
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	315,990,334.31	315,990,334.31
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	315,990,334.31	315,990,334.31
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(100,699,572.30)	(100,699,572.30)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	215,290,762.01	215,290,762.01

Төв аймгийн Батсүмбэр сумын Баянгол цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	712,419,300.00	711,347,800.00	1,071,500.00	99.8
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	29,963,000.00	32,366,900.00	(2,403,900.00)	108.0
132001	Орон нутгийн төсвөөс	29,963,000.00	32,366,900.00	(2,403,900.00)	108.0
1310	УЛСЫН ТӨВЛӨРСӨН САНХҮҮЖИЛТ	682,456,300.00	678,980,900.00	3,475,400.00	99.5
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	682,456,300.00	678,980,900.00	3,475,400.00	99.5
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	833,809,400.00	778,291,814.84	55,517,585.16	93.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	833,809,400.00	778,291,814.84	55,517,585.16	93.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	833,809,400.00	778,291,814.84	55,517,585.16	93.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	636,868,200.00	599,366,438.43	37,501,761.57	94.1
210101	Үндсэн цалин	397,319,800.00	367,603,624.82	29,716,175.18	92.5
210102	Нэмэгдэл	223,468,700.00	198,703,438.49	24,765,261.51	88.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	13,325,000.00		
210104	Урамшуулал	16,079,700.00	19,734,375.12	(3,654,675.12)	122.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,098,300.00	67,903,083.78	11,195,216.22	85.8
210201	Тэтгэврийн даатгал	53,675,100.00	46,285,249.70	7,389,850.30	86.2
210202	Тэтгэмжийн даатгал	6,355,800.00	5,434,453.19	921,346.81	85.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,177,900.00	2,877,022.71	300,877.29	90.5
210204	Ажилгүйдлийн даатгал	3,177,900.00	2,620,390.89	557,509.11	82.5
210205	Эрүүл мэндийн даатгал	12,711,600.00	10,685,967.29	2,025,632.71	84.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,163,000.00	22,516,487.63	5,646,512.37	80.0
210301	Гэрэл, цахилгаан	7,367,900.00	7,329,850.05	38,049.95	99.5
210302	Түлш, халаалт	20,795,100.00	14,786,637.58	6,008,462.42	71.1
210303	Цэвэр, бохир ус	0.00	400,000.00	(400,000.00)	
2105	Нормативт зардал	61,960,900.00	61,116,355.00	844,545.00	98.6
210502	Хоол, хүнс	61,960,900.00	61,116,355.00	844,545.00	98.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,152,000.00	2,919,000.00	233,000.00	92.6
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	3,152,000.00	2,919,000.00	233,000.00	92.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,567,000.00	21,470,450.00	96,550.00	99.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,173,700.00	16,086,650.00	87,050.00	99.5
210902	Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал	5,393,300.00	5,383,800.00	9,500.00	99.8
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		139,943,071.47		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		66,148,644.25		

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 16,425.2 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцооллын 3 алдаа илэрснийг аудитын явцад бүрэн залруулав. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний биет бус хөрөнгөнд 5,761.0 мянган төгрөг тусгаагүй байна.
- Шилжүүлэн авсан 5,033.3 мянган төгрөгийг үндсэн хөрөнгийг хандиваар авсан гэж буруу бүртгэсэн байна.
- Шилжүүлэн авсан 5,630.9 мянган төгрөгийн бараа материалыг хандиваар авсан гэж буруу бүртгэсэн зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна”, 15.2-т “нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Аудитаар илэрсэн 2,601.1 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 2,756.4 мянган төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.2 Залруулаагүй зөрчил

Аудитаар нийт 2,601.1 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч 4 зөвлөмж хүргүүлээ.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 8.1.5-д "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8.3-д "Санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч тэдгээрийн аль нэгийг ойлгоход хамааралтай нэмэлт мэдээллээр хангана" гэж заасантай тус тус нийцэхгүй, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг тайлбар тодруулгын хамт бэлтгэж байх.

2. Өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант хугацааны эцэст 2,501.1 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 "Хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өр төлбөр үүсгэхгүй ажиллах зөвлөмж хүргүүлэв.

3. Зардлын дансны асуудалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг батлагдсан норматив, хүүхдийн ирцтэй тулган шалгахад 100.0 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цэцэрлэгийн хүүхдийн хоолыг олгохдоо анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах зөвлөмж хүргүүлэв.

4. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 184 ширхэг 35,343.6 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” тухай 271 дүгээр тогтоолын 7.1-д “төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ”, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийг чанар байдлыг үнэлэн, ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, Төв аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж шийдвэрлүүлэн, бүртгэх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 10-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
								Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мөнгөн гүйлгээний биет бус хөрөнгөнд 5,761.0 мянган төгрөг тусгаагүй байна	1	5,761.0			1	5,761.0	1	5,761.0		
2	Шилжүүлэн авсан 5,033.3 мянган төгрөгийг үндсэн хөрөнгийг хандиваар авсан гэж буруу бүртгэсэн байна.	1	5,033.3			1	5,033.3	1	5,033.3		
3	Шилжүүлэн авсан 5,630.9 мянган төгрөгийн бараа материалыг хандиваар авсан гэж буруу бүртгэсэн	1	5,630.9			1	5,630.9	1	5,630.9		
	Дүн	3	16,425.2			3	16,425.2	3	16,425.2		

Төв аймгийн Батсүмбэр сумын Баянгол цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг батлагдсан норматив, хүүхдийн ирцтэй тулган шалгахад 100.0 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.	1	100.0					1	100.0				
2	Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.	1	-					1	-				
3	Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 184 ширхэг 35,343.6 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.	1	-					1	-				
4	Тайлант хугацааны эцэст 2,501.1 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.	1	2,501.1					1	2,501.1				
	Дүн	3	2,601.1					3	2,601.1				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт 171 мэдээллээс 5 мэдээллийг хугацаа хоцроож, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1 гүйлгээний 2,057.9 мянган төгрөг, зарлагын 2 гүйлгээний 15,351.8 мянган төгрөгийн мэдээллийг байршуулаагүй байна.	1	17,409.7					1	17,409.7
Нийт дүн	1	17,409.7					1	17,409.7

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn